



**ГОЛОМТ БАНК ХК-ИЙН 2025 ОНЫ НЭГДҮГЭЭР ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/	
Тайлагнах хугацаа	2025.01.01 – 2025.06.30
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: Голомт банк ХК РД: 2075377 Хаяг: Голомт банкны Төв байр, Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22 Улаанбаатар 15160, Монгол улс Утас: 1800-1646 (24/7) 7011-1646 (Дотуур утас) Факс: 11-313155 И-мэйл: mail@golomtbank.com Вэб сайт: golomtbank.com
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	808,657,306 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Э.Батхорлоо /Хөрөнгө оруулалтын ахлах менежер/ Тайлан хянасан: З.Солонго /ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга/

	Тайлант жилийн санхүүгийн тайлан /Хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
--	---

Санхүүгийн байдлын тайлан

	САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
--	-----------------------

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (IFRS-д нийцсэн)

2025/06/30

ГОЛОМТ БАНК

Төгрөгөөр

	Балансын зүйл	2024/12/31	2025/06/30
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,010,591,987,644.36	3,802,604,677,383.29
1.1.1	Бэлэн мөнгө	111,054,352,785.93	143,800,837,738.48
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	3,113,449,943,984.55	2,905,632,959,461.80
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1,785,614,923,989.30	753,081,396,046.04
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	472,766,884.59	89,484,136.96
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	951,188,249,819.09	706,521,463,198.73
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	566,906,794,347.18	671,349,018,599.61
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	384,468,778,629.50	35,185,894,862.65
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,709,257,248.37	65,450,688.07
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(1,896,580,405.97)	(78,900,951.60)
1.3	Хөрөнгө оруулалт	1,250,291,795,897.74	1,350,238,536,005.74
1.3.1	Арилжааны үнэт цаас	218,545,828,089.47	232,160,332,040.86
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	599,448,356,718.27	658,833,381,454.82
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	160,989,900,000.00	166,550,600,000.00
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	223,491,950,000.00	242,307,570,000.00
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	31,213,386,741.85	38,416,292,021.28
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	16,602,374,348.14	11,970,360,488.77
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	7,351,381,160,926.83	7,917,654,308,031.05
1.4.1	Хэвийн зээл	7,039,068,398,097.43	7,645,429,305,290.21
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	185,548,197,773.95	258,991,051,413.23
1.4.3	Хэвийн бус зээл	30,064,500,558.99	66,584,819,868.31
1.4.4	Эргэлзээтэй зээл	29,705,719,914.02	39,643,792,156.90
1.4.5	Мүү зээл	166,011,565,865.31	117,269,763,816.80
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(30,625,780,949.22)	(33,654,159,279.87)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	103,801,283,154.78	62,633,666,326.80
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(172,192,723,488.44)	(239,243,931,561.32)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	235,679,985,318.17	281,206,846,198.96
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	50,473,778,627.32	27,896,841,731.37
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	17,468,356,316.11	16,570,544,146.42
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	5,345,938,483.11	4,751,937,067.95

Page 1 of 3

1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	27,659,483,828.11	6,574,360,517.00
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	477,002,875,806.63	92,104,200,969.50
1.7.1	Бусад тооцоо	455,362,811,360.66	31,989,023,961.93
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	4,971,404,481.97	6,380,303,925.71
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	13,154,667,088.24	7,972,856,676.24
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	41,269,932,252.62
1.7.5	Татварын авлага	-	-
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.7.7	Бусад	3,513,992,875.76	4,492,084,153.00
1.8	Үндсэн хөрөнгө	200,103,975,743.89	663,938,329,013.86
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	8,014,077,161.72	6,586,475,093.92
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	39,545,780,522.50	65,276,539,768.50
1.11	Биет бус хөрөнгө	22,685,884,543.91	28,589,796,827.56
	Нийт хөрөнгийн дүн	15,596,959,552,012.20	14,942,618,014,222.50
2	ОР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	3,662,217,696,076.35	3,478,131,919,588.57
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	3,662,206,569,250.00	3,478,117,495,148.44
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	11,126,826.35	14,424,440.13
2.2	Хадгаламж	4,866,240,282,260.61	5,342,576,111,440.82
2.2.1	Хугацаагүй хадгаламж	618,543,460,720.30	613,237,768,527.28
2.2.2	Хугацаатай хадгаламж	4,046,214,592,815.44	4,499,987,384,574.33
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	47,965,232,579.33	50,433,700,687.30
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	153,516,996,145.55	178,917,257,651.92
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,409,274,173,867.93	2,775,453,802,175.97
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	1,238,373,130,139.57	987,311,918,128.52
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	1,168,088,707,060.72	1,787,060,288,808.98
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(8,539,309,942.27)	(8,623,227,431.62)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	11,351,646,609.90	9,704,822,670.09
2.4	Бусад эх үүсвэр	3,048,029,447,670.34	1,734,223,681,657.92
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	1,365,462,269,202.72	1,554,611,389,068.77
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	-	-
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	30,393,867,033.98	30,253,568,457.52
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	1,535,727,730,351.86	39,859,462,838.27
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	54,366,715,784.76	43,278,499,523.26
2.4.6	Бусад	52,297,754,540.06	58,526,511,579.28
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(12,723,186,053.12)	(10,766,586,339.61)
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	22,504,296,810.08	18,460,836,530.44
2.5	Дериватив санхүүгийн ор төлбөр	904,690,945.84	15,268,290,969.96

2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	100,472,397,868.79	55,586,680,727.14
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	79,454,802,787.71	111,915,781,023.27
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
	Нийт өр төлбөрийн дүн	14,166,593,491,477.60	13,513,156,267,583.70
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	202,164,326,500.00	202,164,326,500.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	-
3.1.2	Энгийн хувьцаа	202,164,326,500.00	202,164,326,500.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	301,481,119,995.04	301,481,119,995.04
3.3	Халаасны хувьцаа	-	-
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	14,901,681,628.98	14,901,681,628.95
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	798,606,421,397.38	900,679,317,584.83
3.6	Бусад өөрийн хөрөнгө	113,212,511,013.19	10,235,300,930.00
3.6.1	Хувьцааны опцион	-	-
3.6.2	Нөөцийн сан	692,165,747.14	687,165,747.14
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	-	-
3.6.4	Эрдэлийн сангийн нөөц	102,966,274,415.44	-
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-
3.6.6	Хөрвөх өр төлбөр	-	-
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	-	-
3.6.8	Бусад	9,554,070,850.61	9,548,135,182.86
	Өөрийн хөрөнгийн дүн	1,430,366,060,534.58	1,429,461,746,638.82
	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	15,596,959,552,012.10	14,942,618,014,222.50

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүүгийн удирдлагын газрын захирал


СУГ Бүртгэлийн бодлого, хяналтын хэлтсийн захирагч



А.Одонбаатар

С.Мөнхтуяа

С.Урантөгс

2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт  АУДИТЫН ХОРООНЫ ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ, ШИЙДВЭР 2025 оны 06 сарын 17 Дугаар 25/06 Улаанбаатар хот Хурал биетээр болон Zoom platform-оор, 2025 оны 06 сарын 17-ны өдөр болсон бөгөөд дараах гишүүд оролцов: <table><tr><td>Аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Жэймс Б.Двайер</td><td>Гүйцэтгэх захирал А.Одонбаатар</td></tr><tr><td>Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг</td><td>ТУЗ-ийн НБД З.Солонго</td></tr><tr><td>Аудитын хорооны хараат бус гишүүн А.Пикер</td><td>ДАГ-ын захирал А.Туяа</td></tr><tr><td>Аудитын хорооны хараат бус гишүүн Х.Холзахкер</td><td></td></tr><tr><td>Аудитын хорооны гишүүн Д.Мөнхтөр</td><td></td></tr></table> ТУЗ-ийн хараат бус гишүүн Р.Сүжан, ТУЗ-ийн гишүүн Ж.Үнэнбат, О.Ганжолоо нар Аудитын хорооны хуралд оролцов. Хуралдсан цаг: 2025.06.17-ны өдөр, 10:00 – 12:40 Танилцуулах асуудлууд: - Макро эдийн засгийн тойм - Санхүүгийн үр дүн (2025.05.31-ний байдлаар болон 2025.06.30-ны урьдчилсан байдлаар) - Хөндлөнгийн аудитын зөвлөмжийн биелэлт Танилцуулга 1. Макро эдийн засгийн тоймыг Гүйцэтгэх захирал А.Одонбаатар, НУГ-ын Эдийн засгийн судалгааны Эдийн засгийн шинжээч Б.Анунжин нар танилцуулав. Тэмдэглэл: - Аудит хорооны гишүүд Засгийн газраас зарласан төслүүдийн талаар асуусан бөгөөд Эдийн засгийн шинжээч Б.Анунжин төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв. Танилцуулга 2. Санхүүгийн үр дүн (2025.05.31-ний байдлаар болон 2025.06.30-ны урьдчилсан байдлаар)-г Гүйцэтгэх захирал А.Одонбаатар, СУГ-ийн захирал С.Мөнхтуяа нар танилцуулав. АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА  ЖЭЙМС Б.ДВАЙЕР	Аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Жэймс Б.Двайер	Гүйцэтгэх захирал А.Одонбаатар	Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг	ТУЗ-ийн НБД З.Солонго	Аудитын хорооны хараат бус гишүүн А.Пикер	ДАГ-ын захирал А.Туяа	Аудитын хорооны хараат бус гишүүн Х.Холзахкер		Аудитын хорооны гишүүн Д.Мөнхтөр	
Аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Жэймс Б.Двайер	Гүйцэтгэх захирал А.Одонбаатар										
Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг	ТУЗ-ийн НБД З.Солонго										
Аудитын хорооны хараат бус гишүүн А.Пикер	ДАГ-ын захирал А.Туяа										
Аудитын хорооны хараат бус гишүүн Х.Холзахкер											
Аудитын хорооны гишүүн Д.Мөнхтөр											

3.1 | Үйл ажиллагааны үр дүн

Голомт банкны 2025 оны 1-р хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн голлох үр дүн

1. Fitch агентлаг Голомт банкны зээлжих зэрэглэлийг B+ Тогтвортой хэмээн үнэллээ. 2024 оны 11 сард Moody's үнэлгээний агентлаг банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг B2 болгон өсгөсөн бол 2025 оны 3-р сарын 11-нд олон улсын үнэлгээний Fitch агентлаг Голомт банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B+" тогтвортой хэмээн үнэлээд байна. Уг үнэлгээ нь Голомт банкны ашиг орлого өссөн, зээлийн багцын чанар сайжирсан болоод зээлийн багцыг илүү төрөлжүүлсэн зэрэг хүчин зүйлсэд суурилан үнэлэгджээ. Ийнхүү Голомт банк нь дэлхийн тэргүүлэх Fitch, Moody's, S&P Global агентлагуудаар зэрэг үнэлгээ хийлгэв.
2. Банк нь 2025 онд Тогтвортой усны менежментийг дэмжих ажлын хүрээнд эх үүсвэр татаж, жижиг дунд бизнес эрхлэгч нарт 20 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий санхүүжилт олгосон зэрэг үйл ажиллагааны хүрээнд "Усны элч" банкаар шалгарав. Банкны зүгээс мөн харилцагчиддаа тогтвортой ус ашиглалт болон ус хэмнэлтийг сайжруулах сургалт зөвлөгөөг байнга хүргэж ажиллаж байна
3. Голомт банк SIMPL хөрөнгө оруулалтын байгууллагаас урт хугацааны ногоон зээлийн санхүүжилт татлаа. Голомт банк Сингапур улсын "Saison Investment Management Private Limited" буюу SIMPL хөрөнгө оруулалтын байгууллагаас урт хугацаат ногоон зээлийн санхүүжилтийг хоёр дахь удаагаа амжилттай татан төвлөрүүллээ. Тус ногоон зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг байгаль орчинд ээлтэй төслүүдийг санхүүжүүлэхэд зориулахаас гадна Монгол Улсын Ногоон Таксономын дагуу сэргээгдэх эрчим хүч, ногоон барилга гэх мэт олон төрлийн ногоон зээлийн санаачилгыг дэмжих зорилготой юм.
4. Голомт банк 2 салбар тооцооны төвийг шинээр байгууллаа. 2025 оны 1-р улиралд иргэдэд банк санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй байлгах зорилгын хүрээнд сувгийн өргөжилттэй холбоотой ажлууд хийгдсэн. Үүнд бид Соёолж молл худалдааны төв шинэ салбар нээх шийдвэр авсан бөгөөд Зүүнхараа тооцооны төвийн үйл ажиллагааг 2025/01/20-нд эхлүүлээд байна. Мөн Завхан аймагт салбар нээх үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажил явагдаж байна. Харилцагчдад илүү тав тухтай орчинд банкны үйлчилгээг хүргэх, ажилтнуудыг таатай ажлын байранд үр бүтээлтэй ажиллуулах зорилгын хүрээнд УБ-т 4 салбар тооцооны төв, орон нутагт 2 салбар тооцооны төвд байршил өөрчлөх, талбай өргөтгөх зэрэг засвар тохижуулалтуудыг хийлээ.
5. Голомт банк 2024 оны хүлэмжийн хийн ялгарлыг тооцуулан баталгаажуулаа. Голомт банк нь Нүүрстөрөгчийн Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл /PCAF/-ийн гишүүнээр 2023 оны 2-р сард элсэн орсон бөгөөд тухайн аргачлалыг ашиглан нийт зээлийн багцын хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцож байна. 2024 оны хүлэмжийн хийн ялгаруулалтыг 1.8 сая тон хэмээн тооцоолсон ба 2023 оны ялгаруулалтаас харьцангуй өндөр байгаа шалтгаан нь хүлэмжийн хийн ялгаруулалтын дийлэнх хэсгийг эзэлж буй хамрах хүрээ 3-санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгаруулалтад тооцооллын аргачлалыг шинэчлэн хөрөнгө оруулалтаас үүдэлтэй ялгаруулалтыг нэмсэнтэй холбоотой юм. Мөн 2024 онд салбаруудын эрчим хүч, дулаанаас ялгарч буй хүлэмжийн хийг тооцож эхэлсэн билээ. Хог хаягдлаас үүдэлтэй болон бензин, дизель түлш зэргээс ялгарч буй хүлэмжийн хийг мэдэгдэхүйц түвшинд бууруулаад байна. Бид мөн нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн багцыг 2030 онд 10%-д хүргэх зорилттой ажиллаж байгаа ба 1-р улирлын байдлаар ногоон зээлийн хэмжээг нэмэгдүүлэн 319 тэрбум төгрөгт хүргэн нийт зээлд эзлэх хувийг 4.2%-д хүргэн ажиллаж байна.
6. Голомт банк Алтны Форум 2025 арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Голомт банк Алтны форум арга хэмжээг 6 дахь жилдээ амжилттай зохион байгуулж алт олборлогч топ аж ахуйн нэгж, уул уурхайн машин механизм, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, нийлүүлэгч байгууллагын 300 орчим төлөөлөл оролцон уул уурхайн салбар, тэр дундаа алтны зах зээлийн орчинд гарсан өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаар хэлэлцэж, ирээдүйн төлөв байдлын тухай санал бодлоо солилцлоо. 2023 оноос энэхүү арга хэмжээний үеэр сайн үйлсийн аян, хандивын үйл ажиллагааг өрнүүлж, цугларсан мөнгийг хүүхэд, багачуудын ирээдүйд зориулан хандивлаж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд дуудлага худалдаанаас олсон нийт 126 сая төгрөгийг хүүхдийн төлөөх төслүүдэд хандивлаж, хүүхэд, багачуудад ээлтэй илүү сайхан ирээдүйг бүтээхэд хөрөнгө оруулсан юм. Алтны Форум 2025 арга хэмжээний үеэр "Элдэв Эрдэнэт" хэмээх Модон могой жилийг бэлгэшээж урласан 999 сорьц бүхий, 1 унц жинтэй алтан медалионыг дуудлага худалдаанд оруулж, олсон 90 сая төг-н орлогыг "Зүрх мартаггүй" төсөлд дахин хандивлахаар болсон. Энэхүү арга хэмжээ нь салбартаа тэргүүлэгч, манлайлагчдыг нэг дор цуглуулан, уул уурхайн

салбарыг цаашлаад улс орны эдийн засгийг хөгжүүлэх оновчтой шийдэл, боломжийг хамтдаа эрэлхийлсэн үр дүнтэй үйл ажиллагаа болж өндөрлөлөө.

7. The Bank Of New York Mellon Corporation (“BNY”)-тэй хамтран улаанбаатар хотноо хоёр дахь удаагаа комплаенсийн семинарыг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд зохицуулагч байгууллагууд, BNY-ийн төлөөлөгчид, Монголын банк санхүүгийн салбарын Комплаенсийн мэргэжилтэн, ажилтнууд зэрэг 100 гаруй зочид төлөөлөгчид оролцов. Улаанбаатар хотноо хоёр дахь удаагаа Комплаенсийн семинарыг зохион байгууллаа. Голомт банкны 30 жилийн ойг угтаж байгаа энэ удаагийн энэхүү зөвлөгөөн бидэнд олон талын үзэл бодлоо хуваалцах, тулгамдаж буй сорилтуудыг хэлэлцэж, Комплаенсийн стандартыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах боломжуудыг олгосон арга хэмжээ боллоо. BNY банк болон Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас олон улсын стандарт, салбарын туршлага, олон улсын гуйвуулгын эрсдэл, гол чиг хандлагууд, Комплаенсийн үйл ажиллагаанд хиймэл оюун ухааныг ашиглах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох, Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үнэлгээ зэрэг сэдвүүдийг танилцуулсан.
8. Голомт банк ОУ-ын хөрөнгө оруулагч санхүүгийн байгууллагуудаас 21 сая ам.долларын урт хугацаат санхүүжилт татав. Энэхүү санхүүжилтийг татсанаар бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийнхээ санхүүгийн хэрэгцээг дэмжих, зээлийн хүртээмжийг сайжруулах, импорт экспортын эргэлтийг нэмэгдүүлэх боломжийг харилцагчдадаа олгоно гэж үзэж байна.
9. Голомт Банкны Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал 2025 оны 4-р сарын 17-нд боллоо. Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-н тав дахь Хараат бус гишүүн Сингапур улсын иргэн Ноён Ронил Сүжан шинээр томилогдсон билээ. Ингэснээр Голомт Банкны ТУЗ-ийн 9 гишүүдээс 5 хараат бус гишүүдээс бүрдсэн ба энэхүү үйл явдал нь ТУЗ-ийн хараат бус шийдвэр гаргалт, зохистой засаглал, хариуцлагатай байдлыг улам бататгаж, урт хугацаанд тогтвортой ашигтай үйл ажиллагааны баталгаа болж байна.
10. Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдэд зориулсан “SheLeads” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Голомт банк нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих стратегийн хүрээнд эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих маш олон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнүүдээс онцлох чухал арга хэмжээ болсон нь SheLeads арга хэмжээ бөгөөд арга хэмжээний үеэр эдийн засгийн хөгжилд үзүүлэх эмэгтэйчүүдийн нөлөөлөл, оролцоог нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн сургалт, илтгэлүүд тавигдаж бизнес эрхлэгч эмэгтэйчүүд өөрийн сайн туршлага, түүхээсээ хуваалцаж, нээлттэй хэлэлцүүлгийг өрнүүлээ.
11. “Mongolia Investment Forum: New York 2025” Чуулгын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллан, өөрсдийн олон улсын хөрөнгийн захын түншүүдийг урьж оролцууллаа. Энэхүү арга хэмжээ нь Нью-Йорк хотод зохион байгуулагдсан бөгөөд Голомт банкны олон улсын бондын андеррайтерууд болох Deutsche bank, Korea Investment Securities Asia, санхүүгийн зөвлөх Frontier Strategies, хуулийн фирмүүдийг урьж оролцуулан, ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж, Гүйцэтгэх Захирал А.Одонбаатар “Монгол улсын ирээдүйн санхүүжилт, бондын зах зээл ба зээлжих зэрэглэл” сэдэвт хэлэлцүүлэгт панелистаар оролцлоо. Арга хэмжээгээр Монголд хөрөнгө оруулах сонирхолтой хөрөнгө оруулагчдад Монголын эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчны талаар мэдээлэл өгсөн арга хэмжээ боллоо.
12. 2024 оны Тогтвортой Хөгжлийн Тайлангаа боловсруулан нийтэлсэн.
Энэхүү тайлангийн гол ололтуудыг дурдвал:
 - Банк өөрийн үйл ажиллагааны хүлэмжийн хийн ялгарлыг 2023 оноос 56%-иар буурууллаа. Мөн өөрийн үйл ажиллагаа болон санхүүжилтээр дамжуулан, ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлыг 2030 онд 30%-иар 2050 онд 50%-иар бууруулах зорилт тавин ажиллаж байна.
 - Банк тайлант онд нийт ₮390 тэрбумын тогтвортой, ногоон санхүүжилтийг олгож, ногоон зээлийн багцаар дамжуулан нийт 4,700 гаруй ажлын байр, 99 тэрбум төгрөгийн нэмүү өртгийг бий болгов.
 - Хүлэмжийн хийн протокол болон Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл (PCAF - Partnership for Carbon Accounting Financials) аргачлалын дагуу банкны өөрийн үйл ажиллагаа болон санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг хамрах хүрээ 1,2,3-ын хүрээнд олон улсын байгууллагаар тооцуулж (нийт 1.8сая тнCO₂e), хариуцлагатай банкны зарчимны хүрээнд дотоод аудитын газраас баталгаажуулалт авсан.

- Голомт банк 2024 оны Тогтвортой санхүүжилтийн шилдэг банк, Тэрбум мод сангийн шилдэг дэмжигч байгууллагаар шалгарлаа. Түүнчлэн Голомт банкны төв оффисын барилга АНУ-ын ногоон барилгын зөвлөлөөс LEED O+M (Leadership in Energy and Environmental Design Operations and Maintenance) стандартын "GOLD" түвшний гэрчилгээг хүртэв.
- Харилцагч болон ажилтнуудад тогтвортой, ногоон санхүүжилтийн сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж (21 ААН, 386 борлуулалтын менежер) ногоон эдийн засагт шилжих санаачилгуудыг дэмжсээр байна.
- Голомт банк нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөөх хүчин чармайлтад бодит хувь нэмэр оруулж, банкны стратеги, зорилго зорилтуудаа НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд болон НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), Санхүүгийн санаачилга-Хариуцлагатай Банкны Зарчмууд зэрэг олон улсын стандартуудтай уялдуулан ажиллаж байна.

13. Голомт банк нь ISO/IEC (International Electrotechnical Commission) 27701:2019 стандартын гэрчилгээг авч, хүний хувийн мэдээллийн нууцлалын удирдлагын тогтолцоогоо баталгаажууллаа. Тус стандарт нь ISO/IEC 27001 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн системийг өргөтгөсөн хувилбар бөгөөд хувь хүний мэдээллийг хамгаалах, боловсруулах, хадгалахтай холбоотой олон улсын шилдэг туршлагуудыг хэрэгжүүлдэгийг гэрчилдэг.

Олон улсын хамтын ажиллагаа

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Голомт банк гадны банкуудтай худалдааны санхүүжилтийн хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлж, нийт 48 сая ам.долларын худалдааны санхүүжилтийг хятадын банкуудаас батлууллаа.

蒙商银行 MENG SHANG BANK 中国银行 BANK OF CHINA

内蒙古银行 Bank of Inner Mongolia ICBC

Томоохон БНХАУ-ын банкнуудаас зээлийн шугам татав



Эх сурвалж: SWIFT WATCH



50 сая ам.долларын бондыг 2025 оны 1-р сарын 9-нд Люксембургийн Хөрөнгийн Биржид бүртгүүлээ.



40 сая USD
GREEN BOND

10 сая USD
SOCIAL BOND

Moody's B2 /тогтвортой/




S&P Global B+ /тогтвортой/

FitchRatings B+ /тогтвортой/

Санхүүгийн үр дүн






САНХҮҮ ҮР ДҮН

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ



Монголбанк тайлангийн суурьтай


ЗЭЭЛИЙН ЗАДАРГАА, ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Монголбанк тайлангийн суурьтай

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ, ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ
/тэрбум төгрөг/



ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР (%)



ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА (%)




НИЙТ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ
/тэрбум төгрөг/



ЗЭЭЛ, ХАРИЛЦАГЧИЙН ЭХ ҮҮСВЭР (%)



ДУНДАЖ АКТИВЫН ӨГӨӨЖ (%)




Монголбанк тайлангийн суурьтай

МОНГОЛБАНКНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (%)



ГАДААД ВАЛЮТЫН ЭРСДЭЛИЙН ХАРЬЦАА (%)



ХОЛБООТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ <20%



ХОЛБООТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ <5%



Монголбанк тайлангийн суурьтай

3.2 Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт

	2024Q1	2024Q2	2024Q3	2024Q4	Limits
Liquidity ratio	36.82%	33.67%	30.85%	35.42%	≥29%
LCR	136.89%	129.21%	109.54%	158.93%	≥100%
NSFR	115.71%	104.07%	101.34%	102.35%	≥100%

Харилцагчийн анхны шаардлагаар төлбөр гүйцэтгэх банкны чадварыг хангах, банкны актив, пассивын эргэн төлөгдөх хугацаа, бүтцийг тэнцвэртэй байлгах зорилгоор Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг Монголбанкнаас 25% гэж тогтоосон байдаг. Голомт банкны хувьд дотооддоо Актив, пассивын бодлогын хүрээнд 2024 онд тус харьцааг 29%-аас дээш хангаж ажиллахаар тогтоосон бөгөөд эдгээр харьцаануудыг 2024 оны турш хангаж ажилласан байна. Монголбанкны зохистой харьцаанаас гадна Голомт банк нь дотооддоо Базелын хорооноос боловсруулсан хөрвөх чадварын харьцаанууд болох LCR, NSFR-г тогтмол тооцоолж, хянаж явдаг. LCR буюу Liquidity Coverage Ratio нь банканд хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхэд бэлэн мөнгөний хэрэгцээ доод тал нь хуанлийн 30 хоног байгаа эсэхийг илэрхийлэх харьцаа үзүүлэлт бөгөөд банк тус харьцааг 2024 онд тогтоосон лимитээс дээгүүр буюу 100%-аас дээш барьж ажилласан байгаа нь банк богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлээ зохистой түвшинд хангаж ажилласан болохыг илэрхийлж байна. Харин NSFR буюу Net stable funding ratio нь банкны урт хугацааны активын санхүүжилтийг хангах урт хугацааны тогтвортой пассивын хүрэлцээтэй байдлыг илэрхийлэх харьцаа үзүүлэлт ба тус харьцааг мөн 100%-аас дээш хангаж ажилласан нь банкны урт хугацааны хөрвөх чадварын эрсдэл нь зохистой түвшинд байгааг илтгэж байна. Аливаа хөрвөх чадварын богино хугацааны эрсдэл үүссэн тохиолдолд банк нь эзэмшиж буй ТБҮЦ эсвэл ЗГҮЦ-аа барьцаалж Монголбанк болон бусад арилжааны банкуудаас овернайт репо хэлцэл хийх, богино хугацаат своп хэлцэл хийх замаар төлбөрийн чадвараа хангах боломжтойгоос гадна тодорхой валютын хувьд хэрэгцээ үүссэн тохиолдолд бусад арилжааны банкуудтай харилцан депозит байршуулах замаар эрсдэлээ удирдах боломжтой юм.

3.3 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл

Макро эдийн засгийн нөхцөл байдал

2025 оны эхний хагас жилд гадаад худалдааны эргэлт 12.1 тэрбум ам.долларт хүрсэн ч өмнөх оноос 8.7 хувиар буурлаа

- Гадаад худалдааны эргэлт өмнөх оноос буурахад экспортын орлого 16.6%-иар буурсан нь голлон нөлөөллөө. Экспорт өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум ам.доллараар буурахад нүүрсний экспортын орлого 2.1 тэрбум ам.доллар, угаасан ноолуур 148 сая ам.доллар, боловсруулаагүй газрын тосны экспорт 31.4 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ. Харин зэсийн хүдэр ба баяжмалын экспортын орлого 897.9 сая ам.доллараар, алтны экспорт 55.9 сая ам.доллараар өссөн нь нийт экспортын орлогот эергээр нөлөөлсөн байна.
- Цаашлаад энэ оны эхний хагас жилд нийт 37.9 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх оноос 6.7%-иар буурсан бол нүүрсний хилийн үнэ тонн тутамд 70 ам.доллар болсон нь өмнөх оноос 65.7%-иар буурсан байна. Улмаар нүүрсний экспортын орлогын нийт экспортын орлогот эзлэх хувь 40% болж буурсан бол зэсийн экспортын орлого 35.7% болж өсжээ.
- Харин нийт импорт 5.5 тэрбум ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 2.8%-иар буюу 150 сая ам.доллараар өссөн байна. Нийт импортын зардал өсөхөд суудлын автомашины импорт 208 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин ачааны машин болон бусад импортын хэмжээ өмнөх оноос буурсан байна.

Төсвийн орлогын тасалдал үргэлжилж, төсвийн тэнцэл 758 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа

- Улсын төсвийн орлого эхний хагас жилд 13.2 их наяд төгрөг болж өмнөх оноос 6.9%-иар буурсан бол төсвийн зардал 8.2%-иар өсөж 13.9 их наяд төгрөг хүрлээ. Улмаар төсвийн тэнцлийн алдагдал 758 тэрбум төгрөг болж өмнөх оноос 159%-иар буурлаа.
- Шинэ ЗГ байгуулагдаж 2025 оны төсөвт тодотгол хийх, төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн УИХ-д өргөн бариад байгаа билээ.
- 2025 оны төсвийн тодотголд төсвийн орлогыг 10.6%-иар бууруулахаар тусгасан бол төсвийн зардлыг ердөө 5.6%-иар бууруулж, төсвийн тэнцлийг 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай батлахаар УИХ-д өргөн барьсан.
- Манай улсын төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувьд 38.1% байгаа нь хөгжиж буй орнуудын дундаж хэмжээ болох 20-25%-ийн түвшнээс маш өндөр байгааг илэрхийлж байна. Цаашлаад төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх шаардлагатай болохыг Монгол улсын төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тасралтгүй зөвлөсөөр ирсэн. Иймд Монгол улсын нийгэм, эдийн засагт чухал нөлөөтэй улсын төсвийн тогтвортой байдлыг хангаж ажиллах нь цаашдын эдийн засагт чухал нөлөөтэй байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч, инфляц харьцангуй тогтворжиж байна

- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны эхний хагас жилд 43 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 3.7%-иар өссөн бол 2023 оноос 11.6 их наяд төгрөг буюу 36.9%-иар өссөн байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт валютын хадгаламж 5.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 16.9%-иар өссөн, төгрөгийн хадгаламж 15%-иар буюу 2.9 их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- Инфляц 2025 оны 6 сарын байдлаар 8.2% болж төв банкны зорилтот интервалын дээд түвшний орчимд байна.
- 2025 оны 6 сарын байдлаар төгрөгийн ханш ам.долларын эсрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.9%-иар суларсан бол 2025 он гарснаас хойш 4.7%-иар суларсан нь валютын хадгаламж өсөхөд голлон нөлөөллөө. Харин гадаад валютын нөөц 6 сарын байдлаар 5.2 тэрбум ам.долларын түвшинд байна.
- Цаашлаад төлбөрийн тэнцлийн алдагдал сүүлийн 4 сарын турш бууралттай байгаа нь нөөцөд үзүүлэх дарамтыг бууруулж байна. Төлбөрийн тэнцэлд гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь эергээр нөлөөлж байгаа бол урсгал дансны алдагдал сөргөөр нөлөөлж байна.

Голомт банкны баримталж буй стратегийн хэрэгжилт

Дижитал шилжилтийн стратегийн хүрээнд:

Голомт банк нь харилцагчдынхаа дижитал хэрэглээг дэмжих, дижитал төлбөр тооцоо урамшуулах зорилгоор олон төрлийн сугалаа, буцаан олголт, купон болон оноотой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Энэхүү хүрээнд 1-р улирлын онцлох лоялти хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Нийт 53 мянган харилцагчдад 37 байгууллагыг оролцуулсан урамшуулалт хөтөлбөрүүдийг зохион байгуулсан байна.

Мөн дижитал сувгаар бид шинэлэг бүтээгдэхүүнийг үргэлж харилцагчдадаа хүргэхийг зорьдог. 1-р улиралд онцлох бүтээгдэхүүнийг дурдвал:

- 10 сая төгрөг хүртэлх зээлийн эрхтэй UnionPay Splendor Plus виртуал зээлийн картыг SocialPay-ээс хормын дотор авах боломжтой боллоо.
 - Жилд 6 удаа олон улсын нисэх буудлуудын лоунжаар үнэгүй үйлчлүүлэх.
 - Хятад хийсэн гүйлгээ бүртээ 1-5% -ийн буцаан олголт авах боломжтой.
- Egomt.mn-д “Миний хүүхэд” үйлчилгээ нэмэгдлээ. Эцэг эхчүүд хүүхдийнхээ данс, карт, интернет банк, хадгаламж зэрэг бүхий л санхүүгийн хэрэгцээг хянах, удирдахад боломжтой боллоо.
- Голомт банк 30 жилийнхээ ойг тохиолдуулан картын загвараа бүрэн шинэчилж, UNIVERSE шинэ картуудаа танилцууллаа

- Олон улсын болон дотоодын лояалти хөтөлбөрүүд болон хөнгөлөлтийн сүлжээ (Visa perks and offers, mastercard priceless and priceless specials, union pay, amex loyalty networks).
- Картын бүх төрлийн лимит болон эрхийн тохиргоогоо дижитал сувгуудаар удирдах, валют хооронд хөрвүүлэг хийх, кредит картаасаа шилжүүлэг хийх боломжууд
- Брэнд тус бүрийн онцлог, давуу тал бүхий бүтээгдэхүүнүүдийн ялгарал
- Давтагдашгүй гэрэлд тодорч, хүрэхэд мэдрэгдэх интерактив дизайн, чиглэл заасан Notch технологи болон орчин үеийн босоо загвар.
- Гэр бүлийн гишүүдэд зориулсан дэд карт үүсгэх боломж.
- VIP харилцагчдад зориулсан 18гр болон 22граммын метал карт
- VIP харилцагчдад зориулсан консьерж үйлчилгээнүүд, солонгос туркын эмнэлгүүд
- Applepay, socialpay болон бүх төрлийн дижитал хэтэвчид холбож NFC, QR төлбөр тооцоог монголд болон гадаадад шимтгэлгүй хийх боломж.

Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих стратегийн хүрээнд:

- Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зээл
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан шуурхай зээл
- Бүх төрлийн дотоодын шуурхай баталгаа
- ВЕКСЕЛ мөнгөжүүлэх үйлчилгээг банк санхүүгийн салбарт анх удаа
- CU сүлжээ дэлгүүрийн авлага барьцаалсан зээл зэрэг харилцагчдынхаа үйл ажиллагааг дэмжих, процессийг хурдасгах зорилгоор шинэ бүтээгдэхүүнүүд нэвтрүүлээ.

Хөрөнгө оруулагчдын харилцааг бэхжүүлэх стратегийн хүрээнд:

Аливаа нээлттэй байгууллагын хувьд хөрөнгө оруулагчидтай болон бусад хөрөнгийн зах зээлд оролцож буй талуудтай үр дүнтэй харилцааг бий болгох, мэдээллийн хүртээмжтэй, ил тод байдлыг дэмжих нь голлох стратегийн чиг үүрэг байдаг. Бид 2024 онд Хөрөнгө оруулагчидтай харилцах нэгжийг үүсгэн байгуулж, Investor relations чиг үүргийг стратегийн үндсэн зорилтуудын нэг болгон ажиллаж байна. Хөрөнгө оруулагчид болон бусад оролцогчдын харилцааг бэхжүүлэх, мэдээллийг хүртээмжтэй байлгах чиглэлээр улирал бүр үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн танилцуулах Earnings call болон хөрөнгө оруулагчдын уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байна. Мөн хувьцааны шинжээчдэд мэдээлэл хүргэх зорилгоор Analyst day-г зохион байгуулсан ба банк дотооддоо мөн IR workshop-г амжилттай зохион байгууллаа. Management Discussion and Analysis-г бид нэгдүгээр улиралд нийтэлж банкны голлох санхүүгийн үр дүн болоод удирдлагын багийн зүгээс тайлбарласан тайланг хүргэлээ. Голомт банкны Гүйцэтгэх Захирал нийт хөрөнгө оруулагч, оролцогч талуудад CEO Letter-г мөн хүртээл болгоод байна. Цаашид бид олон нийтэд хүргэх мэдээллийг ил тод байлгахаар батлагдсан Investor Relations календарын дагуу холбогдох үйл ажиллагааг зохион байгуулан, мэдээллийг хүргэн ажиллаж байна.

3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/
-----	--

Зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг

Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргүүдийг санхүүгийн байдлын тайланд тусгадаггүй ч эдгээр нь тодорхой хэмжээний эрсдэлийг агуулж байдаг тул Банкны нийт эрсдэлийн нэгээхэн хэсэг гэж үздэг.

Эдгээр хэрэглүүрүүдийн үндсэн зорилго бол харилцагчдад шаардлагатай үед нь санхүүжилтийн эх үүсвэрийг бэлэн байлгахад оршино. Баталгаа нь хэрэв харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг барагдуулах гэсэн цуцлагдах боломжгүй баталгаанууд бөгөөд эдгээр нь зээлтэй ижил төрлийн эрсдэл агуулдаг. Бичиг баримтын болон худалдааны аккредитив нь Банкнаас тодотгон заасан нөхцөлд гуравдагч этгээдэд тохиролцсон дүн хүртэлх хөрөнгийг авахыг харилцагчийн өмнөөс бичгээр зөвшөөрсөн үүрэг хүлээлт бөгөөд холбогдох бараа таваар буюу мөнгөн хадгаламжуудаар баталгаажсан байдаг тул зээлээс арай бага эрсдэлтэй байдаг.

Зээл, баталгаа болон аккредитив хэлбэрээр үүсгэсэн зээлийн шугамын ашиглаагүй хэсгээр Банк зээл олгох үүргийг хүлээдэг. Ашиглаагүй зээлийн шугамын хувьд харилцагч тухайн шугамыг ашигласан тохиолдолд л ашигласан зээлийн нийт хэмжээгээр Банк зээлийн эрсдэлд өртөх магадлалтай.

Гэвч харилцагч тодорхой зээлийн нөхцөл, шалгуурыг хангасан тохиолдолд зээлийн шугам авах эрх үүсдэг тул Банкны хүлээж болох алдагдлын дүн ашиглагдаагүй байгаа зээлийн шугамаас бага байдаг.

Мянган төгрөгөөр	2025 оны 06 сарын 30
Олгосон санхүүгийн баталгаа	98,840,447
Олгосон гүйцэтгэлийн баталгаа	501,837,948
Аккредитив	149,739,665
Ашиглаагүй зээлийн шугам	718,327,627
Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг	1,468,745,686
Хасах нь: зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүргийн үнэ цэнийн бууралтын сангийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал	(10,882,080)
Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг	1,457,863,606

4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/
---	--

2025.01.30-ны өдрийн хурлын шийдвэр

Хэлэлцсэн асуудал: Д.Баясгалантай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр: Д.Баясгаланд хөрөнгө оруулалтын зээл олгохыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2025.03.13-ны өдрийн хурлын шийдвэр

1. Хэлэлцсэн асуудал: “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулах тухай

Шийдвэр: “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-тай хамтран ажиллах гэрээг заасан нөхцөлөөр батлахыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2. Хэлэлцсэн асуудал: “Монгол масс медиа” ХХК-ийн охин компани болох “Медиа боловсол суваг” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулах тухай

Шийдвэр: “Монгол масс медиа” ХХК-ийн охин компани болох “Медиа боловсол суваг” ХХК-тай хамтран ажиллах гэрээг заасан нөхцөлөөр батлахыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

3. Хэлэлцсэн асуудал: “Монгол масс медиа” ХХК-ийн охин компани болох “Ийгл Бродкастинг” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулах тухай

Шийдвэр: Монгол масс медиа ХХК-ийн охин компани болох “Ийгл Бродкастинг” ХХК-тай хамтран ажиллах гэрээг заасан нөхцөлөөр батлахыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

4. Хэлэлцсэн асуудал: “Изи пэй норбула ББСБ” ХХК-тай холбоотой зээлийн шугамыг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгох тухай

Шийдвэр: “Изи пэй норбула ББСБ” ХХК-тай холбоотой зээлийн шугамыг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгохыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

5. Хэлэлцсэн асуудал: “Голомт капитал ҮЦК” ХХК-тай холбоотой зээлийн шугамыг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгох тухай

Шийдвэр: “Голомт капитал ҮЦК” ХХК-тай холбоотой зээлийн шугамыг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгохыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2025.05.30-ны өдрийн хурлын шийдвэр

1. Хэлэлцсэн асуудал: “Мандал даатгал” ХК-тай үл хөдлөх хөрөнгийн даатгалын гэрээ байгуулах тухай

Шийдвэр: “Мандал даатгал” ХК-тай үл хөдлөх хөрөнгийн даатгалын гэрээг заасан нөхцөлөөр батлахыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2. Хэлэлцсэн асуудал: “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-тай паркийн тасалбар худалдан авах гэрээ байгуулах тухай

Шийдвэр: “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-тай паркийн тасалбар худалдан авах гэрээг заасан нөхцөлөөр батлахыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

3. Хэлэлцсэн асуудал: Д.Баясгаланд кредит картын лимитийг нэмэгдүүлэх тухай.

Шийдвэр: Д.Баясгаланд кредит картын лимитийг нэмэгдүүлэхийг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

4. Хэлэлцсэн асуудал: “Голомт капитал ҮЦК” ХХК-тай холбоотой ажилтны зээлийн хамтын ажиллагааны гэрээг сунгах тухай

Шийдвэр: “Голомт капитал ҮЦК” ХХК-тай холбоотой ажилтны зээлийн хамтын ажиллагааны гэрээг 2 жилээр сунгахыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

5. Хэлэлцсэн асуудал: “Эгүнэ оюун” ХХК-тай холбоотой ажилтны зээлийн хамтын ажиллагааны гэрээг байгуулах тухай

Шийдвэр: “Эгүнэ оюун” ХХК-тай холбоотой ажилтны зээлийн хамтын ажиллагааны гэрээг 1 жилийн хугацаатай байгуулахыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2025.06.17-ны өдрийн хурлын шийдвэр

1. Хэлэлцсэн асуудал: Очир төв ХХК ӨБХ борлуулах тухай

Шийдвэр: Голомт банк ХК-ийн зээлийн өр төлбөрт авсан Очир төв ХХК өмчлөх бусад хөрөнгийг борлуулахыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

5 | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

Хувьцаа эзэмшигчид

№	Хувьцаа зэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
1	Голомт Файнэншил Групп ХХК	624,240,527	77.20%
2	Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	42,120,816	5.21%
3	Бодь Интернэшнл ХХК	48,461,497.00	5.99%
4	Олон нийт	93,834,466	11.60%
	Нийт	808,657,306	100%

Голомт Файнэншил
Групп ХХК

Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр бизнесийн төвлөрсөн үйл ажиллагаа явуулдаг 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого баримталдаг ба

	Голомт банкны энгийн хувьцаа болон зарим хувьцаанд хөрвөх зээлүүдийг эзэмшдэг.
Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	Свисс-Мо Инвестмэнт Эй Жи нь Швейцарь улсын хөрөнгө оруулалтын сан бөгөөд 2010 онд үүсгэн байгуулагдсан. Вальют арилжаа, нисэх онгоцны буудал, агаарын тээвэр болон зочид буудлын салбаруудад хувьцаа эзэмшдэг. 2011 онд Голомт банканд хөрөнгө оруулалт хийснээр хувьцаа эзэмших болсон.
Бодь Интернэшнл ХХК	Бодь Интернэшнл ХХК нь үндэсний хөрөнгө оруулалттайгаар 1993 онд байгуулагдсан, томоохон групп компаниудын нэг бөгөөд өдгөө үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт аялал жуулчлалын салбаруудад үйл ажиллагаагаа явуулдаг. Голомт Инвестмэнт Лимитэд Голомт Инвестмэнт Лимитэд нь 2014 онд Монголын анхны томоохон групп компани болох “Бодь интернэшнл” ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан.
Олон нийт	Голомт банк 2022 онд хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг хийснээр банкны нийт хувьцааны 11.6 хувь болох 93 мянга гаруй нэгж хувьцааг олон нийт эзэмшиж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Голомт банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4-р сарын 17-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхимд 88.73 хувийн ирцтэйгээр танхим болон зайнаас хосолсон хэлбэрээр хурал зохион байгуулагдсан. Хурлын үр дүнд дараах асуудлуудыг хэлэлцэж баталсан.

Шийдвэрүүд:

1. Голомт банк ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгох тухай;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

Чүлтэмийн Мөнхцэцэг,
Жигжидийн Үнэнбат
Дагвын Мөнхтөр
Очирпүрэвийн Ганжолоо

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

Жеймс Б. Двайер,
Александр Пикер
Роберт В. ван Свитен
Ханс Холзхакер
Ронил Сүжан

5. Банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхгийг нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн тухай;
6. Голомт банкны дүрмийг батлах тухай;
7. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх тухай.

Мөн ХЭХ-аар дараах мэдээллийг танилцуулсан. Үүнд:

1. 2024 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн – Хөндлөнгийн аудитын дүгнэлт
2. 2024 оны цэвэр ашгаас ногдол ашин хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол
3. 2024 оны ТУЗ-ийн ажлын тайлан, төсөв

Төлөөлөн удирдах зөвлөл



Хатагтай
Ч.Мөнхцэцэг
ТУЗ-ийн дарга



Ноён
Д.Мөнхтөр
ТУЗ-ийн гишүүн



Ноён
Ж.Үнэнбат
ТУЗ-ийн гишүүн



Ноён
О.Ганжолоо
ТУЗ-ийн гишүүн



Ноён
Б.Двайер
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Ноён
Александр
Пикер
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Ноён
Роберт
В.Ван
Свитен
ТУЗ-ийн
Хараат бус
гишүүн



Ноён
Ханс
Холзхакер
ТУЗ-ийн
Хараат бус
гишүүн



Ноён
Ронил Сүжан
ТУЗ-ийн
Хараат бус
гишүүн



З.Солонго
ТУЗ-ийн
Нарийн
Бичгийн



А.Туяа
Дотоод аудитын
газрын захирал

ТУЗ-ийн дэргэдэх хороод:

	гишүүд	албан тушаал
Эрсдэлийн удирдлагын хороо	 Александр Пикер*	Хорооны дарга
	 Роберт В.Ван Свитен*	Хорооны гишүүн
	 Жэймс Б.Двайер*	Хорооны гишүүн

			Хорооны гишүүн	
		Ч. Мөнхцэцэг		
	Аудитын хороо		Хорооны гишүүн	
		Ж.Үнэнбат		
			Хорооны дарга	
		Жэймс Б.Двайер*		
			Хорооны гишүүн	
		Александр Пикер*		
			Хорооны гишүүн	
		Ч.Мөнхцэцэг		
			Хорооны гишүүн	
		Д.Мөнхтөр		
	Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо		Хорооны гишүүн	
		Ханс Холзхакер*		
			Хорооны дарга	
		Жэймс Б. Двайер*		
			Хорооны гишүүн	
		Александр Пикер*		
			Хорооны гишүүн	
		Ч.Мөнхцэцэг		

Нэр дэвшүүлэх хороо		Хорооны дарга
		Хорооны гишүүн
		Хорооны гишүүн
	Александр Пикер*	
	Роберт В.Ван Свитен*	
	Ч.Мөнхцэцэг	

Удирдлагын баг



А.Одонбаатар

Гүйцэтгэх захирал



Г.Ганболд

Ерөнхийлөгч



Т.Отгон

Эрсдэл хариуцсан
захирал



М.Сайнбилэг

Мэдээлэл
технологи
хариуцсан захирал



С.Мөнхтуяа
Санхүүгийн

удирдлагын газрын
захирал



М.Наранхүү

Зээлийн газрын
захирал



Ц.Байгалмаа

Жижиг, дунд банкны
газрын захирал



Б.Содболор

Нөөцийн
удирдлагын газрын
захирал



Б.Сугар-Эрдэнэ
Байгууллагын
банкны газрын
захирал



Б.Энхзаяа

Олон улсын банкны
газрын захирал



Г.Уянга

Хүний нөөцийн
удирдлагын газрын
захирал



Б.Зориг

Маркетинг, олон
нийттэй харилцах
газрын захирал



Г.Мандах
Харилцагчийн
бүртгэлийн газрын
захирал



Ё.Пүрэвбат
Бүртгэл тооцооны
газрын захирал



Х.Пүрэвдорж
Захиргааны газрын
захирал



З.Сугар
Иргэдийн банкны
газрын захирал



О.Батцэнгэл
Дижитал банкны
газрын захирал



А.Нямсүрэн
Харилцагчийн
үйлчилгээний газрын
захирал



Б.Энхтүвшин
Зээл цуглуулах
газрын захирал



Ж.Оюун
Дижитал
шилжилтийн
газрын захирал

6 Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Эрсдэлийн удирдлага

2025 оны хагас жилд зээлийн багцын чанарт онцгой анхаарал хандуулан ажилласнаар банкны чанаргүй зээлийн түвшин 2.7 хувь, зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ 107 хувьд хүрэв.

Голомт банкны эрсдэлийн засаглалын хүрээнд “Гурван шугамын загвар”-ын дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажилласан ба зах зээлийн хүндрэл нөхцөлд үүсэж болох эрсдэлийг стресс тестийн үр дүнгээр тодорхойлж, өөрийн хөрөнгийн болоод хөрвөх чадварын дотоод үнэлгээний аргачлал (ICAAP, ILAAP)-ын дагуу нөөц интервалыг тооцож, эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд тусган гэрлэн дохионы аргачлалын дагуу тогтолцооны бүрэлдэхүүнийг улам сайжруулан ажиллаж байна.

“Гурван шугамын аргачлал”-д нийцтэй байдлыг тодорхойлж олон улсын жишгийн дагуу баталж, мөрдөж ажилладаг. Үүнд:

- Банкны бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааныхаа эрсдэлийг хариуцан ажилладаг бизнес нэгжүүд болон тэдгээрийг дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд “Нэгдүгээр шугам”-д хамаарна.
- “Нэгдүгээр шугам”-д хамаарах нэгжүүдийн эрсдэлээ хэрхэн удирдаж байгаад хяналт тавих, банкны хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүрэгтэй нэгжүүд “Хоёрдугаар шугам”-д хамаарна.
- Хараат бус дотоод аудитын чиг үүрэгтэй нэгжүүд “Гуравдугаар шугам”-д хамаарна.

Банк эрсдэлийн таксономид дурдсан эрсдэлүүдийн материаллаг байдалд үндэслэн гол эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрт хязгаарлалт тогтоож ажиллав. Энэхүү хязгаарлалт нь банкны “**Эрсдэлийн аппетитийн мэдэгдэл**”-д тусгагдаж жил бүр шинэчлэн бадлагддаг.

Түүнчлэн, Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал (ICAAP)-ыг банк дотооддоо тооцож нэгтгэсэн стресс тестэд ашиглах замаар холбогдох хороонд танилцуулан өөрийн хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажилладаг.

Стратеги үнэлгээ – Зах зээлийн нөхцөл байдалд өөрчлөлт гарах, эсвэл өөрчлөлт гарахаар хүлээгдэж буй нөхцөлд банкны ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгөд эрсдэлийн аппетитд хэрхэн нөлөөлөхийг тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж дүгнэлт хийж дахин үнэлж стресс тестийн гол төсөөллүүд дээр үндэслэдэг ба үр дүнг дараа жилийн стратеги, бизнесийн төлөвлөгөөг боловсруулалтад тусгаж ажилладаг. Энэхүү хариу арга хэмжээний зохицуулагч байгууллагын бодлого, зохистой хэмжээний хүрээнд мөрдөгдөж боловсруулагддаг.

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт нь санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэн болон ирээдүйн мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж, алдагдал хүлээх эрсдэл юм. Хүү, валютын ханш, арилжаа, хөрөнгө оруулалтын зориулалттай үнэт цаас, хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт эсвэл зах зээлийн хөдөлгөөнөөс хамаарч, банкны нээлттэй байгаа позицод зах зээлийн эрсдэл нэмэгддэг.

Тайлант хугацаанд Монгол Улсын макро эдийн засгийн орчин тогтворжиж эхэлсэн боловч геополитикийн эрсдэлүүд нэмэгдэж, санхүүгийн зах зээлд хувьцаа, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, зэрэг эрсдэлүүд тулгарсан ч банк зах зээлийн эрсдэлийн удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлснээр болзошгүй алдагдлаас хамгаалж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэн ажиллаж байна.

2025 оны хагас жилд Голомт банк нээлттэй гадаад валютын позицуудын хувьд Монголбанкнаас тогтоодог шаардлагуудыг хангахаас гадна банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд бүрэн нийцүүлэн ажилласан. Түүнчлэн АПХ-оос батлагдсан лимитийн хүрээнд валютын ханшийн эрсдэлээс учирч болзошгүй алдагдлыг “Value at Risk” аргачлалаар тооцож, өдөр бүр хяналт тавин ажиллав.

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь бэлэн мөнгө эсвэл бусад хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөөр санхүүгийн өр төлбөрийг гүйцэтгэхэд хүндрэл үүсэх эрсдэл юм.

Банкны хөрвөх чадвар 2025 оны нэгдүгээр хагас жилийн турш Монголбанкнаас тогтоосон зохистой түвшин болон банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдлийн хүрээнд Цалинтогтоосон стандартын дагуу банк богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор хөрвөх чадварын хүрэлцээтэй байдлын харьцаа (LCR), дунд урт хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааг (NSFR) тогтмол тооцож, хангаж ажиллалаа.

Банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг улам сайжруулах, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор банкны дотоод бодлого, журам, аргачлал, хүндрэлийн үеийн төлөвлөгөөг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, мөрдөн ажиллалаа.

Мөн түүнчлэн Базел III стандартын дагуу хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-аар учирч болзошгүй хөрвөх чадварын эрсдэлийг тодорхойлж, стресс тестийг тогтмол гүйцэтгэн үр дүнг шийдвэр гаргалтад ашиглан хөрвөх чадварын эрсдэлийг удирдан ажиллаж байна.

7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
---	---

Банкны нийт гаргасан 808,657,306 ширхэг энгийн хувьцааг 2024 оны 12-р сарын 31 ний байдлаар нийт 19638 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.Үүнд:

Голомт Файнэншил Групп ХХК	Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр бизнесийн төвлөрсөн үйл ажиллагаа явуулдаг 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого баримталдаг ба Голомт банкны энгийн хувьцаа болон зарим хувьцаанд хөрвөх зээлүүдийг эзэмшдэг.		
Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	Свисс-Мо Инвестмэнт Эй Жи нь Швейцарь улсын хөрөнгө оруулалтын сан бөгөөд 2010 онд үүсгэн байгуулагдсан. Вальют арилжаа, нисэх онгоцны буудал, агаарын тээвэр болон зочид буудлын салбаруудад хувьцаа эзэмшдэг. 2011 онд Голомт банканд хөрөнгө оруулалт хийснээр хувьцаа эзэмших болсон.		
Бодь Интернэшнл ХХК	Бодь Интернэшнл ХХК нь үндэсний хөрөнгө оруулалттайгаар 1993 онд байгуулагдсан, томоохон групп компаниудын нэг бөгөөд өдгөө үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт аялал жуулчлалын салбаруудад үйл ажиллагаагаа явуулдаг.		
Голомт Инвестмэнт Лимитэд	Голомт Инвестмэнт Лимитэд нь 2014 онд Монголын анхны томоохон групп компани болох “Бодь интернэшнл” ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан.		
Олон нийт	Голомт банк 2022 онд хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг хийснээр банкны нийт хувьцааны 11.6 хувь болох 93 мянга гаруй нэгж хувьцааг олон нийт эзэмшиж байна.		
№	Хувьцаа зэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
1	Голомт Файнэншил Групп ХХК	624,240,527	77.20%
2	Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	42,120,816	5.21%
3	Бодь Интернэшнл ХХК	27,661,497	3.42%
4	Голомт Инвестмэнт Лимитэд	20,800,000	2.57%
5	Олон нийт	93,834,466	11.60%
	Нийт	808,657,306	100%

8 | Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ТУЗ-ийн хурал, шийдвэр, тогтоолтой холбоотой мэдээлэл

2025 оны эхний хагас жилд Голомт банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл нийт 9 удаа ээлжит болон ээлжит бус хурал зохион байгуулж, нийт 25 асуудлыг хэлэлцэн зөвлөлдөж, 18 тогтоол, шийдвэрийг батлав.

ТУЗ-өөс баталсан тогтоол, шийдвэрүүд:

- Стратеги бизнес төлөвлөгөөтэй холбоотой
 - Нийт 2 тогтоол гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.
- Хөрөнгө оруулалттай холбоотой
 - Нийт 13 шийдвэр гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.
- Дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт сайжруулахад чиглэсэн
 - Нийт 1 шийдвэр гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

4. Бодлогын баримт бичиг, дүрэм журам, засаглалыг сайжруулахад чиглэсэн

- Нийт 2 бодлого журмыг сайжруулан шинэчилсэн байна.

Голомт банк нь нээлттэй хувьцаат компани болсонтой холбоотойгоор хөрөнгө оруулагчдад шаардлагатай мэдээ, мэдээллийг зохицуулагч байгууллагын холбогдох журмуудын дагуу цаг тухай бүрд олон нийтэд мэдээлэн ажилласан.

Тус тайлан мэдээ нь МХБ болон Голомт банкны “Хөрөнгө оруулагчдад” хэсэгт нээлттэй байрлаж байгаа тул хувьцаа эзэмшигч та бүхэн нэг бүрчлэн танилцах боломжтой. Үүнд:

- Аудитлагдсан санхүүгийн тайлан
- Жилийн болон хагас үйл ажиллагааны тайлан
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан
- Ногдол ашиг хуваарилалтын тайлан
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлаас гарсан шийдвэр, тогтоол
- Компанийн засаглалын кодекс хэрэгжилтийн тайлан

1. Эрсдэлийн удирдлагын хороо

Бүрэлдэхүүн

Хорооны дарга:

Хорооны гишүүд:

Александр Пикер, ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Жэймс Б. Двайер, Хараат бус гишүүн

Роберт В. ван Свитен, Хараат бус гишүүн

Ч.Мөнхцэцэг, Гишүүн

Ж.Үнэнбат, Гишүүн

5 гишүүний дийлэнх буюу 3 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Хорооны хурал

- Эрсдэлийн удирдлагын хороо нь 2025 оны эхний хагас жилд нийт 16 удаа хуралдсан.
- нийт 49 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

Хэлэлцсэн асуудал

- 20 тэрбум төгрөг буюу түүнээс зээлтэй групп компаниудын хүсэлтийг шийдвэрлэсэн Зээлийн хорооны хяналт;
- Эрсдэлийн тайлан мэдээлэл, эрсдэлийн удирдлага бодлого;
- бусад цаг үеийн асуудал, мэдээлэл.

2. Аудитын хороо

Бүрэлдэхүүн

Хорооны дарга:

Хорооны гишүүд:

Жэймс Б. Двайер, ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Александр Пикер, Хараат бус гишүүн

Ханс Холзхакер, Хараат бус гишүүн

Ч.Мөнхцэцэг, Гишүүн

Д.Мөнхтөр, Гишүүн

5 гишүүний дийлэнх буюу 3 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Хорооны хурал

- Аудитын хороо нь 2025 оны эхний хагас жилд нийт 6 удаа хуралдсан.

- нийт 20 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан

Хэлэлцсэн асуудал

- Банкны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, санхүүгийн үр дүн;
- Дотоод аудитын тайланг тайлагнах;
- Дотоод аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлийг тайлагнах, төлөвлөгөөг батлуулах;
- Монголбанкны шалгалтын үр дүн;
- Хөндлөнгийн аудитын үр дүн;
- Бусад.

3. Нэр дэвшүүлэх хороо

Бүрэлдэхүүн

Хорооны дарга:	Александр Пикер, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
Хорооны гишүүд:	Жэймс Б. Двайер, Хараат бус гишүүн Ч.Мөнхцэцэг, Гишүүн

3 гишүүний дийлэнх буюу 2 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн, үүний нэг нь засаглалын мэргэжилтэн.

Хорооны хурал

- Нэр дэвшүүлэх хороо нь 2025 оны эхний хагас жилд нийт 5 удаа хуралдсан.
- нийт 15 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

Хэлэлцсэн асуудал

- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулалт;
- Бүтэц зохион байгуулалт, Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төсөв.

4. Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо

Бүрэлдэхүүн

Хорооны дарга:	Жэймс Б. Двайер, Хараат бус гишүүн
Хорооны гишүүд:	Александр Пикер, Хараат бус гишүүн Ч.Мөнхцэцэг, Гишүүн

3 гишүүний дийлэнх буюу 2 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн, үүний нэг нь засаглалын мэргэжилтэн.

Хорооны хурал

- Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо нь 2025 оны эхний хагас жилд 1 удаа хуралдсан.
- нийт 1 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

Хэлэлцсэн асуудал

- ГУ багийн гүйцэтгэл, урамшуулал.

9 | Ногдол ашгийн мэдээлэл

Тайлант он	ТУЗ-ийн шийдвэр гаргасан огноо	Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг	Нийт ногдол ашиг	Бүртгэлийн өдөр	Олгосон өдөр
2024	2025-02-17	100 төгрөг	80.9 тэрбум төгрөг	2025.03.26	2025.04.25

10 | Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

“Eco volunteer” хөтөлбөр

	Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд Голомт банк санаачлан хэрэгжүүлж буй “Eco Volunteer” хөтөлбөрийн дагуу Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах зорилгоор 80 гаруй хүүхэд Баянзүрх дүүрэг дэх Туул голын ай сав газарт цэвэрлэгээ хийж, орчны бохирдлыг буурууллаа. Голомт банк ажилтнуудынхаа гэр бүл, үр хүүхдийн сайн сайхан байдалд анхааран “Good vibes” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ удаад орчны бохирдлыг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулахын ач холбогдлыг таниулахаар энэхүү сайн дурын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулсан юм. Хүүхдүүд Туул голын ай сав Хөлийн голын 1 км орчмын бохирдол ихтэй бүсэд 1 тонн орчим хог хаягдал цэвэрлэсэн бөгөөд банкны зүгээс талархал илэрхийлж, “Eco volunteer” сертификат олголоо. “Mentorship” хөтөлбөр Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дараагийн шатанд гаргахад нь чадавхжуулах зорилготой MENTORSHIP 2024 хөтөлбөр хаалтаа хийж 52 харилцагчид сургалт зөвлөх үйлчилгээндээ бүрэн хамрагдаж дууслаа. Харин 2025 оны менторшип хөтөлбөрт 100 харилцагч хамрагдаж эхэллээ. Энэ хүрээнд Банк нь мөн “Орон нутгийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөр” арга хэмжээг эхлүүлсэн. Сэлэнгэ аймгийн Мандал сумын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд 2025.05.02-нд дижитал шилжилт, бизнесийн стратегиа дараагийн шатанд гаргахад хэрхэн тодорхойлох, бизнес модел бүтээх, гүйцэтгэлд суурилсан үр дүн хэрхэн гаргах зэрэг сургалтуудыг орлоо. “Мандах 2025” Голомт банк эх орныхоо тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах, боловсролыг дэмжих зорилгоор их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, оюутнуудыг ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрөөс гадна дадлагажигч хөтөлбөр зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг ба энэ удаа “Мандах 2025” буюу “Салбар дундын судалгаа болон тогтвортой хөгжил” сэдвээр зохион байгуулагдсан ОУ-ын эрдэм шинжилгээний хурлыг ерөнхий спонсороор хамтран ажиллаа. Уг эрдэм шинжилгээний хурал Монгол, Тайланд, БНСУ, Казакстан, Англи, Австрали болон Энэтхэг улсын эрдэмтэн судлаачид оролцов. “Зүрх мартаггүй” төсөл Голомт банкны “Алтантүлхүүр” хүүхдийн сангаар дамжуулан 2020 онд “Зүрх мартаггүй” сайн үйлсийн төслийг дэмжихээр санамж бичиг байгуулснаас хойш санхүүгийн болон бусад дэмжлэгийг тууштай үзүүлэн, албан ёсны түншээр хамтран ажиллаж байна. Төрөлхийн зүрхний гажигтай, ховор оноштой хүүхэд багачуудыг Монголдоо оношлон, мэс засал хийж, бяцхан зүрхнүүдийг аврах зорилготой энэхүү төсөлд Голомт банк 2020 оноос хойш нийт 420 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллаа. Энэхүү төслийн бүрэлдэхүүн одоогийн байдлаар Монгол Улсыг гурав бүтэн тойрч, 54,600 орчим хүүхдэд үзлэг оношилгоо хийж, 1,580 гаруй хүүхдэд амьдрал бэлэглэжээ.
	Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:
	Овог, нэр: Залаа-Уул Солонго Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
	Гарын үсэг:
	Мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн огноо: 2025.07.31